



ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

№2023/009

Сайншанд

Монгол Улсын Иргэний хуулийн 476-480 дугаар зүйл, Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт, Засгийн газрын 2015 оны 430 дүгээр тогтоол, 2016 оны 179 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/06 дугаар тогтоолоор батлагдсан "Дорноговь аймгийн Засаг даргын Хөгжлийн хамтдаа-2" үйл ажиллагааны хөтөлбөрийг үндэслэн нэг талаас нутгийн захиргааны байгууллагыг төлөөлж Дорноговь аймгийн Засаг дарга Очирпүрэвийн Батжаргал, Сайншанд сумын Засаг дарга Чулуунсүхбаатарын Түвшинтөр, нөгөө талаас Сайншанд сумын Зүүнбаян багийн нутагт газрын тос хайх, олборлох, тээвэрлэх үйл ажиллагаа явуулдаг "Доншен газрын тос (Монгол)" ХХК-г төлөөлж ерөнхий захирал Жан Донбо (цаашид компани гэх) нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү гэрээгээр талууд Ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн эдийн засаг, нийгэм, хүний хөгжлийг дэмжих чиглэлээр хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулахад гэрээний зорилго оршино.

1.2.Талууд гэрээг хэрэгжүүлэхдээ хууль дээдлэх, харилцан бие биенээ дэмжих, төсөл болон гэрээтэй холбоотой аливаа асуудлаар хоорондоо ил тод, нээлттэй байдлыг ханган ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтална.

ХОЁР.СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1.Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ашиглалтын болон бүтээгдэхүүн тээвэрлэлт, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тогтвортой хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангана.

2.2.Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бодлого, төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол мэдээлэл өгч, саналыг нь авна.

2.3.Орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр үзүүлсэн дэмжлэг, туслалцаа, түүний зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний талаар тухайн орон нутгийн иргэдэд мэдээлэл хийж саналыг нь авна.

2.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг хуульд заасан хугацаанд өгнө.

2.5.Ашигт малтмал олборлох үйлдвэрийн газарт аюул осол гарсан тохиолдолд нутгийн захиргааны байгууллага, түүнчлэн аж ахуйн нэгж, байгууллага харьяалал харгалзахгүйгээр

тээврийн хэрэгсэл, материал тоног төхөөрөмж, эмийн зүйл олгох, холбооны хэрэгслээр үйлчлэх, аюул ослын үр дагаврыг арилгахад шаардагдах бусад дэмжлэг үзүүлнэ.

2.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах газар, авто зам, цахилгааны эрчим хүч үйлдвэрлэх, хэрэглэх, усан хангамж, дэд бүтцийн барилга байгууламж барих зориулалтаар газар эзэмших, ашиглах зөвшөөрөл авах эрхтэй бөгөөд орон нутгийн удирдлага нь хүсэлтийг хуулийн дагуу шийдвэрлэнэ.

2.7.Автозамын засвар арчлалтын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.

2.8.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт болон байгаль орчны аудит хийлгэсэн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавина.

2.9.Байгаль орчныг хамгаалах талаар Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийн биелэлтэд холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хяналт шалгалт хийх, олборлолтын явцад байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсгэсэн тохиолдолд арилгуулах арга хэмжээг авч ажиллах, хууль бус үйл ажиллагааг таслан зогсооно.

2.10.Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн "Ногоон уурхай"-г холбогдох журмын дагуу урамшуулна.

2.11.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн захиалгаар мэргэшсэн ажилтан бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.12.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг холбогдох байгууллагатай хамтран иргэдэд ил тод, нээлттэй хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулна.

2.13.Орон нутагт жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын ажил үйлчилгээ, бараа бүтээгдэхүүнийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид санал болгож, уг бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг худалдан авахад нь зохих дэмжлэг үзүүлнэ.

2.14.Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардана.

ГУРАВ.ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Ерөнхий зүйл:

3.1.Аймаг, сумын нийгэм, эдийн засаг, дэд бүтэц, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор "Дорноговь Их Хөгжил сан"-д дэмжлэг үзүүлнэ.

3.2.Төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх сумын хот төлөвлөлт болон засаглалыг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд аймаг болон сумын засаг захиргааны байгууллагатай хамтран идэвх санаачилгатай ажиллана.

3.3.Төрийн болон иргэний нийгмийн байгууллага, иргэдтэй олон талт хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, аливаа төсөл хэрэгжүүлэхдээ нутгийн иргэдийн санал, хүсэлтийг харгалзан үзнэ.

3.4.Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэд, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу шат шатны Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлнэ.

3.5.Нутгийн захиргааны байгууллагаас гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийг шаардана.

Орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих чиглэлээр:

3.7.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилийн үйл ажиллагаандаа шаардагдах бараа, ажил, үйлчилгээний жагсаалтыг тухайн оны эхний сард багтаан аймаг, сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

3.8.Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа орон нутгийн тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч аж ахуйн нэгжийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгож болно.

3.9.Тусгай зөвшөөрлийн нийт талбайгаар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль болон холбогдох журмын дагуу эзэмшиж ашиглан гэрээнд заасан хугацааны дагуу газрын төлбөрийг төлнө.

3.10.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайн олборлолт явуулах зорилгоор ашигласан түгээмэл тархацтай ашигт малтмал, гадаргын болон гүний усны төлбөрийг тухайн үед мөрдөгдөж байгаа хууль, эрх бүхий байгууллагаас баталсан тарифын хэмжээгээр тооцож, орон нутгийн төсөвт төлөх ба ус ашиглах нөхцөл нь бусад ус ашиглагчтай адил байна.

3.11.Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих, шаардагдах техник, тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх, компанийн ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр хамтран ажиллана.

3.12.Хүүхдийн сурч боловсрох орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, сайжруулах чиглэлээр хамтран ажиллана.

3.13.Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, гамшгийн үед болон түүний улмаас учирсан хохирлыг арилгах хүрээнд орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлнэ.

Байгаль орчны чиглэлээр:

3.14.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллана.

3.15.Тусгай зөвшөөрлийн талбайн ойр орчинд нутагладаг малчин иргэдийн малын бэлчээр, ундны болон ахуйн хэрэглээний усаа хэрэглэхэд талбайн шав тэмдгийн хүрээнээс гадуур ямар нэг хориг хязгаар тавихгүй байх, нутгийн иргэдийн зорчих зам талбайг хөндөж, хаахгүй байх, зөвхөн тодорхойлогдсон маршрутын дагуу зассан замаар явна.

3.16.Уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн автозамын засвар арчлалтыг бүрэн хариуцна.

3.17.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагддаг агаар, ус, хөрсний шинжилгээг Дорноговь аймаг дахь лабораториудаар жилд 1-ээс доошгүй удаа хийлгэнэ.

3.18.Орон нутгийн засаг захиргаатай хамтран биологийн төрөл зүйлийг хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажилд хамтран ажиллаж, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр:

3.19.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нийт ажилчдын 30 хүртэлх хувьд орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.20.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт, 31 дүгээр зүйлийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангаж ажиллана.

3.21.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутгийн ажиллагсдыг шаардлагатай тохиолдолд дотоод, гадаадын их, дээд сургуульд өөрийн зардлаар сургаж мэргэшүүлж болно.

3.22.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Компани нь Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулиудад бакалаврын түвшинд суралцаж буй, аймгаас шалгарсан оюутнуудад санхүүгийн туслалцаа үзүүлнэ.

3.23.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Дорноговь аймагт байрлах их дээд сургууль, коллежтой хамтран ажиллах, техник технологи, геологи, уул уурхайн инженер, техникийн нарийн мэргэжлийн мэргэжилтэн бэлтгэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

3.24.Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, одой хүнийг ажлын байраар хангах буюу ажиллуулаагүй бол холбогдох хууль, тогтоомжийн дагуу мөнгөн төлбөрийг орон нутгийн ХЭДС-д төлнө.

Соёлын өвийг хамгаалах чиглэлээр:

3.25.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутгийн түүх, ёс заншлыг хүндэтгэж соёлын өвийг хадгалах, түүх соёлын дурсгалт газрыг хамгаалах, уламжлалт мал аж ахуй, говийн бүс нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр төсөл хөтөлбөрийг дэмжин орон нутагтай хамтран ажиллана.

3.26.Орон нутгийн уламжлалт ариун дагшин газар буюу сүсэг бишрэлийн хувьд ач холбогдолтой уул, овоо, рашаан ус зэрэг байгалийн онцлог тогтцуудыг орон нутагтай хамтран хамгаалах, орчны тохижилтыг сайжруулах арга хэмжээг авна.

3.27.Үйл ажиллагаа явуулж байгаа газарт нь археологи, палеонтологийн судалгаа, шинжилгээ явуулахад санхүүжилтийн тодорхой хувийг гаргаж, дэмжлэг үзүүлнэ.

3.28.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уламжлалт мал аж ахуй болон бэлчээр ашиглах, хадгалан хамгаалах, төслийн нөлөөлөлд өртсөн малчин өрхөд зориулсан эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэн малчдын амьжиргааг сайжруулахад нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллана.

ДӨРӨВ.ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХОРОО

4.1.Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий "Хамтын ажиллагааны хороо"-г орон нутгийн төрийн байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна.

4.2.Хороо нь талуудын тэгш оролцоог хангахуйц нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд хорооны бүрэлдэхүүнийг тухайн сумын Засаг дарга томилж, чөлөөлнө.

4.3.Хороо нь "Хамтын ажиллагааны гэрээ"-ний хүрээнд хэрэгжилтийг жил бүр дүгнэн хэлэлцэж, санал, зөвлөмжийг Талуудад хүргүүлнэ. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, тэдгээрийн санхүүжилт нь Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн жилийн батлагдсан төсөвт нийцсэн байна.

ТАВ.ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

5.1.Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор гэрээ байгуулсан талаар орон нутгийн иргэдэд мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 5 хоногийн дотор байршуулна.

5.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээ байгуулснаас хойш ажлын 15 хоногийн дотор гэрээ байгуулсан талаар Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдээлнэ.

5.3.Гэрээний хувийг ажлын 10 хоногийн дотор Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд хүргүүлнэ.

5.4.Талууд гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны эхний улиралд багтаан аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

5.5.Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймгийн Засаг дарга болон Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

ЗУРГАА.ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

6.1.Талууд үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.

6.2.Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

6.3.Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хуулиар хүлээсэн бусад үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

7.1.Гэрээг тайлбарлах болон гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан, зөрчлийг тухай бүр, эв зүйгээр шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

7.2.Хэрэв маргаантай асуудлаар талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

НАЙМ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

8.1.Гэрээг нэг жилийн хугацаатай байгуулна.

8.2.Энэхүү гэрээнд Талууд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

8.3.Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэг адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

8.4.Байгалийн гамшиг, цар тахал, халдварт өвчний улмаас тогтоосон хөл хорио, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, онц байдал, төр засгийн шийдвэр, зах зээлийн нөхцөл байдал хүндэрсэн гэх мэт давагдашгүй хүчин зүйлс нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд шууд сөргөөр нөлөөлсөн тохиолдолд талуудын үүргийн биелэлтийг хойшлуулах болон гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

8.5.Гэрээг дээрх тохиолдолд болон Иргэний хуулийн 480 дугаар зүйлд заасны дагуу дуусгавар болгоно.

8.6.Гэрээг Монгол хэл дээр 3 хувь үйлдэх бөгөөд Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 1 хувь, аймгийн удирдлага 1 хувь, сумын захиргаа 1 хувийг тус бүр хадгална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫГ

ТӨЛӨӨЛЖ:


САЙНШАНД СУМЫН ЗАСАГ ДАРГА

Ч.ТҮВШИНТӨР



АЖ АХУЙ НЭГЖИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"ДОНШЕН ГАЗРЫН ТОС (МОНГОЛ)" ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

 ЖАН ДОНБО

Утасны дугаар: